

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2013 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

## Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

### **1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 11 сард 1 удаа хуралдаж 16 асуудал хэлэлцэн 16 тогтоол батлан гаргалаа. Үүнд:

- Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг баталлаа.
- Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдээс хот, суурин газрын нийтийн эзэмшлийн газар, зам, талбай, эд ахуйг, арчлан хамгаалах, орчноо тохижуулах, цэвэр байлгах талаар дагаж мөрдөх журмыг баталлаа.
- Аймаг, орон нутгийнхаа түүхэн замналаас суралцах, бахархах, ирээдүйд итгэх итгэл, бүтээлч сэтгэлгээг залуу өсвөр үеийнхэндээ төлөвшүүлэх зорилгоор зарим уран бүтээлийг бүх нийтээр судлах, сурах, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрийн хүрээнд хүүхэд, сурагчдад заан сургах шийдвэрийг гаргалаа.
- 2014 оны төсвөөс санхүүжүүлэх боломжгүй болсон Сэлэнгэ телевизийг 2013 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгон татан буулгахаар шийдвэрлэлээ.
- Аймгийн Аудитын газар, Боловсролын газар, Дулаанхаан тосгоны захирагчийн албаны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 17943,2 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн 4 автомашиныг дуудлага худалдаагаар худалдах мөн 11 тээврийн хэрэгсэл, аймгийн Цагдаагийн газрын нийт 4867.2 мянган төгрөгийн 46 нэр төрлийн эд зүйлсийг актлах тогтоол тус тус батлан гаргалаа.
- Сум орон нутгаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй орон сууц, Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 айлын орон сууцыг одоо эзэмшиж байгаа төрийн албан хаагчдад нь хувьчлах шийдвэр гаргалаа.
- Сум байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Цагаануур сум байгуулагдсаны 90 жил, Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль байгуулагдсаны 90 жилийн ойг 2014 оны 7 сард тэмдэглэхийг тус тус зөвшөөрч тогтоолыг баталлаа.
- Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулагдаж буй шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээний эхний шат аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2013 оны 11 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна.

### **2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл, спорт, аялал, жуулчлалын газар, Монгол туургатны “Урамтай шатар” холбоо, аймгийн шатрын холбоо, Орхонтуул сумын “Хурай” ХХК хамтран аймгийн Засаг даргын нэрэмжит “Сэлэнгэ хурай 2013” 11 дүгээр сарын 01-03-ны өдрүүдэд аймгийн төв Сүхбаатар хотноо амжилттай зохион байгуулж аваргуудаа шалгарууллаа. 300 гаруй оюун ухаанаа уралдуулан тэмцээний 8 хүртэлх насны

эрэгтэйчүүдийг Х.Тэмжүүжин /Уран нүүдэл/ клуб, эмэгтэйчүүдийг Б.Мөнгөнзул /Хангарьд/, 12 хүртэлх насны эмэгтэйчүүдийг Г.Учрал /Сэлэнгэ Алаг морьт/, эрэгтэйчүүдийг Э.Нямбилэг /Хэнтий/, А ангиллын эмэгтэйчүүдийг Ү.Үүрийнтуяа /Хан-Алтай/, эрэгтэйчүүдийг их мастер Д.Шаравдорж нар тэргүүллээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас сумын Засаг даргын Тамгын газар, орон нутагт төрийн үйлчилгээг үзүүлдэг төр төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийн, төрийн албан хаагчдын чадавхийг сайжруулж, орон нутгийн төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Зүүнбүрэн суманд аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг 2013 оны 11 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Аймгийн нэгдсэн эмнэлэг, Хан голомт сургалтын төв хамтран “Удирдахуйн ухааны ур чадвар” сэдэвт сургалтыг 2013 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр зохион байгуулж, аймгийн Засаг даргын Тамгын газар Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн 40 гаруй албан хаагчдыг хамрууллаа.

Аймгийн эрүүл мэндийн салбарт анагаах ухааны дэвшилтэт технологи нэвтрүүлэх зорилгоор аймгийн нэгдсэн эмнэлэгт дурангийн мэс заслын аппарат нэвтрүүлэх нээлтийн үйл ажиллагааг 2013 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгууллаа. Аймгийн нэгдсэн эмнэлэгт батлан хамгаалах хууль сахиулах албаны нэгдсэн эмнэлэгийн их эмч хошууч Х.Бат-Оршихоор ахлуулсан 3 эмч удирдлага зохион байгуулалтаар ханган хамтран ажиллаж 6 хүнд дурангийн хагалгааг амжилттай хийсэн байна. Дурангийн хагалгаанд орсон өвчтнүүдийн биеийн байдал сайн байна.

“Бид Сэлэнгийн үр сад” хүүхдийн урлагийн их наадамд дуу, бүжиг, язгуур урлаг, төрлүүдээр аймгийн ерөнхий боловсролын 31 сургууль, орон нутгийн соёл, урлагийн байгууллагуудын дугуйлангийн 3000 гаруй сурагчид оролцож, 450 гаруй хүүхэд Алт, мөнгө, хүрэл медалийн эзэд боллоо. Нэгдсэн дүнгээр Хөтлийн соёлын ордон, Мандал сумын 1-р сургууль, Баруунбүрэн сум, Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн сурагчид тэргүүн байрыг эзэлж, Хүүхдийн авьяас билгийг хөгжүүлж наадамд амжилттай оролцуулсан багш нарын ур чадварыг үнэлэн Түнхэл тосгоны бүжгийн багш н.Эрдэнэцэцэг, Хөтөлийн соёлын ордны багш н.Цэнгэлмаа, Хүүхдийн ордны дуу хөгжмийн багш Б.Амарсайхан нар шалгарлаа. Тус наадамд идэвхитэй сайн оролцсон арван ерөнхий боловсролын сургууль, соёл урлагийн байгууллагуудын захирал, дарга, эрхлэгч нарыг шагнаж урамшууллаа.

Аймгийн “Ургацын баяр 2013” арга хэмжээг 11 дүгээр сарын 16-ны өдөр тэмдэглэн өнгөрүүллээ. Тус арга хэмжээний үеэр “Шилдэг шүлэг” шалгаруулах уралдааныг аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулж, шалгарсан 10 яруу найрагч Сэлэнгэ нутаг, амуу тарианы тухай шүлэг, яруу найргаа сонордууллаа. Мөн 53 дахь намартаа ургацаа хурааж буй тариаланчид 8 төрлөөр шилдгүүдээ шалгарууллаа.

Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат Түшиг сумын “Улаан Овоогийн” нүүрсний уурхайгаас 2013-2014 оны өвөл 1 тн нүүрсийг 80,000 төгрөгөөр, 40 кг-ын нэг шуудай нүүрсийг 4000 төгрөгөөр аймгийн төв Сүхбаатар суманд борлуулахаар гэрээ байгуулан нүүрс борлуулах цэгийг нээн ажиллууллаа. Энэхүү нүүрсний цэг нээгдсэн өдрөөсөө эхлэн байнгын үйлчүүлэгчидтэй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэс, Тогтвортой амьжиргаа 2 төсөлтэй хамтран “Орон нутгийн хөгжлийн сангийн, төлөвлөлт зарцуулалт” сэдэвт сургалтыг аймгийн нийт сумдад зохион байгуулж байна.

“Монгол Улсад үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх авлигатай тэмцэх” үндэсний хөтөлбөрийн төслийн хэлэлцүүлгийг 2013 оны 11 дүгээр сарын 21-

ний өдөр тус аймагт аймгийн Засаг даргын Тамгын газар, Хуульч эмэгтэйчүүдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн Я.Нямжав, гишүүн Б.Түвшинбаяр, Хуульч эмэгтэйчүүдийн холбооны Сэлэнгэ аймаг дахь салбар хамтран зохион байгуулж, төрийн албан хаагчид болон иргэдийн төлөөлөл нийт 120 гаруй хүн оролцож саналаа өглөө.

2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр аймгийн Засаг дарга бизнес эрхлэгчидтэй хамтран “Хамтарч ажиллая” зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа. Аймгийн Засаг дарга орон нутгийн хөгжил дэвшилд бизнес эрхлэгчдийн үзүүлж буй үр нөлөө, Сүхбаатар хотыг хөгжүүлэх чиг хандлагын талаар мэдээлэл хийн бизнес эрхлэгчдийг салбар тус бүрээр нь 3 ангилж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Санжжав, Засаг дарга С.Бүрэнбат, Засаг даргын Тамгын газрын дарга Ө.Сувдаа нараар ахлуулсан салбар хуралдаан зохион байгуулагдан, салбар хуралдаанаас гарсан саналуудыг нэгдсэн хуралдаан дээр танилцуулж, нэгтгэн цаашид хамтран ажиллах чиг хандлагаа тодорхойллоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, “Sanicon” сургалтын төвтэй хамтан 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр төрийн албан хаагчдын нэгдсэн уулзалт, сургалт, семинарыг “Өөрчлөлтийг өөрөөсөө” сэдвийн дор зохион байгуулж, аймгийн Засаг дарга цаг үеийн ажил, аймгийн “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээний үеэр төрийн албан хаагчдын үйл ажиллагааны талаар авсан санал асуулгын дүнгийн тухай мэдээлэл хийж, иргэдээс гаргасан шүүмжлэл, санал хүсэлтийг үндэслэн өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын төрийн албан хаагчдад мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, харилцааны соёл, ёс зүй, хариуцлага хүлээх чадвар, хувь хүний хөгжлийг агуулсан сургалт зохион байгууллаа. Тус уулзалт, семинарт аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс алба, сумын Засаг даргын Тамгын газрын нийт 400 гаруй төрийн албан хаагчид хамрагдлаа.

**Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

**1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

10-р сарын 31-ний байдлаар

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн орлого	13920678.70	12380021.50	88.9
2	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	10805286.00	9264603.10	85.7
3	Орон нутгийн төсвийн зарлага	45154849.20	41225911.80	91.3
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлага	11886500.30	9613889.80	80.9
	Аймгийн ОНХСангийн зарцуулалт	2360453.00	1509669.20	64.0
	Авто замын хөрөнгө оруулалт	241460.90	138178.50	57.2
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	3250900.00	3250900.00	100
5	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	1297525.10	982718.40	75.7
6	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	8657912.00	8657912.00	100
7	Засаг даргын нөөц	389242.00	402088.53	103.3

2013 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 88.9 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 71.9 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 91.3 хувийн биелэлттэй, аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 103.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

**2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:**

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2012 оны 10-р сар	2013 оны 11-р сар
<b>Нэг.Талх, гурил, будаа</b>				
1	Гурил /1-гурил/	1 кг	800	900
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	800, 1800	800, 1800
3	Нарийн боов	1 кг	1800-2300	1800-2300
4	Элсэн чихэр	1 кг	2000	1800
5	Цагаан будаа	1 кг	2200	2200
<b>Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн</b>				
6	Хонины мах	1 кг	6500	6800
7	Үхрийн мах	1 кг	7000	7000
8	Адууны мах	1 кг	6300	5700
9	Ямааны мах	1 кг	6000	5700
10	Дотор мах цувдай	1 кг	4500	3500
11	Хиам, чанасан	1 кг	8500	9000
12	Гахайн мах	1кг	7000	7000
<b>Гурав.Сүүн бүтээгдэхүүн</b>				
12	Сүү /задгай/	1л	800	800
13	Сүү /савласан/	1л	1700-1800	1700-1800
14	Тараг /задгай/	1л	1000	1000
15	Хорхой ааруул	1 кг	5000	8000
16	Айраг	1л	-	-
17	Хуурай сүү /орос/	1 кг	4200	4200
18	Өндөг	ш	330-350	330-350
<b>Дөрөв. Бүх төрлийн өөх тос</b>				
19	Ургамлын тос	1 кг	2900-3500	2900-3500
20	Өөхөн тос	1 кг	1200	1200
21	Шар тос	1 кг	8000	6000
22	Масло /задгай/	1 кг	3000	3000
<b>Тав.Хүнсний ногоо</b>				
23	Төмс/Монгол/	1 кг	600	800
24	Лууван	1 кг	800	1000
25	Манжин	1 кг	800	1000
26	Байцаа	1 кг	600	800
27	Сонгино	1 кг	1500	2000
28	Өргөст хэмх /Монгол/	1 кг	-	-
29	Тарвас /Монгол/	1 кг	-	-
30	Өргөст хэмх	ш	3000-4200	3000-4200

	/даршилсан/			
31	Алаг салат /даршилсан/	ш	2100-2500	2100-2500
Зургаа.Тээвэр шатахуун				
32	Бензин А-80	1 л	1540	1540
33	Бензин А-92	1 л	1650	1650
34	Дизель түлш	1 л	1780	1780

### Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

#### **1.Архивын талаар:**

Тус аймгийн Жавхлант суманд хийгдсэн “Ус хуримтлуулах цөөрөм”-ийн ажлын тайлан болон зураг төслийн баримтууд, Мандал суманд шинээр баригдсан үйлчилгээний төвийн барилгын зураг төслийн баримт, Сүхбаатар сумын 4-р багт баригдсан 168 айлын орон сууц, Орхон сумын “Гудамжны гэрэлтүүлэг”-ийн угсралтын ажил, Алтанбулаг сумын 1 км хатуу хучилттай авто зам, Сүхбаатар сум доторх хатуу хучилттай зам засварын ажлын баримтуудыг Төрийн архивын тасаг нь хүлээн авч хөмрөгийн нөхөн бүрдүүлэлтийг хийлээ.

Архивын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2004-2008 оны 30 баримт, Цагаантолгойн сангийн аж ахуйн 1951-1991 оны 28 хадгаламжийн нэгж, Номгон сангийн аж ахуйн 1976-1991 оны 35 хадгаламжийн нэгжид эрдэм-шинжилгээ техник боловсруулалтын ажлыг хийн мастер хувь үүсгэлээ.

Ерөө хорооны 1971-1992 оны 280 хадгаламжийн нэгж, Хүдэр сумын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны 1978-1980 оны 24 хадгаламжийн нэгж, Номгон сангийн аж ахуйн 1976-1991 оны 131 хадгаламжийн нэгжид хэсэгчилсэн тооллогын ажлыг хийж 60 хадгаламжийн нэгжид нягтлан шалгалтын ажлыг хийж сэлбэн засалт, тоон хэлбэрт шилжүүлэх баримтын судалгааг гаргалаа. Хадгалах хугацаа дууссан баримтыг устгах хэргийн актанд бүртгэлээ.

Ард, иргэд албан байгууллагын хүсэлтийн дагуу нийт 72 архивын хуулбар, магадлагаа 16, тодорхойлолт 19, цалингийн тодорхойлолт 4-ийг гаргаж үйлчиллээ.

### Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

#### **1.Боловсролын чиглэлээр:**

Аймгийн Боловсролын газраас “Хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүй” технологийн ө өёäуä өёäüёёéí óäæääáí û ä аймгийн ерөнхий боловсролын сургуулийн áí ëí í цэцэрлэгийн багш нарын дунд амжилттай зохион байгуулж, б¿ñ á¿äýýñ ø àèäðñáí 5 багшийг өрсөлдүүлэн, Õ°ò°ё ерөнхий боловсролыí сургуулийн áäæ í àðûí “Хувилбарт даалгавраар сурагчдыг хөгжүүлэх арга зүй” сэдэвт илтгэл шалгарч улсын уралдаанд оролцохоор боллоо.

Сургуулийн өмнөх боловсролын бага, дунд бүлгийн сургалтын хөтөлбөрүүдийг баталж бүсийн сургагч багш бэлтгэх сургалтыг үе шаттай зохион байгуулж “Сургуулийн өмнөх боловсролын бага, дунд бүлгийн сургалтын хөтөлбөр арга зүйн шинэчлэл” сэдэвт сургалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж сургуулийн өмнөх боловсролын бага, дунд бүлгийн 200 гаруй багшийг хамрууллаа.

Í ðõí í ðóóë ñòí ûí ерөнхий боловсролын 2-ð сургуулийн çàðëäëüí àæëûí байрны сонгон шалгаруулалтыг 11 дүгээр сарын 08-ны өдөр Төрийн албаны ç° äë° өёéí 63 áóäáä òí äõí í ëüí ääæó аймгийн боловсролын газар, ð° ðëéí àëääí û салбар зөвлөлтэй хамтран зохион байгууллаа.

"Кенгуру" олон улсын математикийн уралдааны сорилгод 24 сургуулийн 1100 гаруй сурагчдыг оролцуулж, мэдлэг чадварыг хөгжүүлэн ажиллалаа.

## **2.Эрүүл мэндийн талаар:**

Аймгийн Эрүүл мэндийн газраас Сайхан сумын эмнэлэгт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч үйл ажиллагааны үндсэн 4 чиглэлээр ажиллалаа. Эмнэлзүйн тохиолдол дээр суурилан Хөтөл сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааг алдагдуулалгүй 40 ортой хээрийн эмнэлгийг дэлгэн мэргэжил аргазүйн зөвлөгөө өглөө. Үүнд: Лаборатори, Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх хэсэг, дотрын тасаг, эрчимт эмчилгээ, хүүхэд, эмэгтэйчүүд, төрөх тасаг, нярайн тасаг, мэс заслын тасаг, хагалгааны дараах өрөө, ариутгал халдваргүйтгэлийн тасаг гэсэн зохион байгуулалтыг хийлээ.

Дэлхийн харвалтын өдрийг тохиолдуулан аймгийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг хамтран тархины харвалттай иргэд, тэдний асран хамгаалагчдад зориулсан эмчилгээ, үйлчилгээ, сургалт сурталчилгааны 14 хоногийн аяныг зохион байгуулж, Сүхбаатар сумын 8 багийн тархины харвалттай 8 иргэнд сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлж байна.

0-3 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх зорилгоор "Тархины саатай хүүхдийн сэргээн засалт" сэдэвт сургалтыг зохион байгуулж сургалтанд нийт 58 их эмч мэргэжилтэн хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн газар хамтран Чихрийн шижин өвчинтэй тэмцэх дэлхийн өдрийг угтаж "Хүрч үйлчлэе" уриатай арга хэмжээг аймгийн төв Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй 4 албан байгууллагад зохион байгуулж нийт 118 төрийн албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа.

Сүхбаатар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны оюутнуудад "ХДХВ/ДОХ-той тэмцэх дэлхий нийтийн өдөр"-г угтан БЗДХ, ХДХВ, ДОХ-ын халдвараас хэрхэн урьдчилан сэргийлэх" эрүүл зан үйлийг хэрхэн төлөвшүүлэх талаар сургалт зохион байгуулж "Үе тэнгийн сургагч багш" бүлгэмийг байгууллаа.

Сүхбаатар сумын Улсын тэргүүний 4-р цэцэрлэгийн нэрэмжит үндэсний бөхийн барилдааныг насны ангилалаар зохион байгуулж нийт 124 хүүхдүүд оролцлоо. 4 насны ангилалд 1-р байранд Х.Энхтулга 2-р цэцэрлэг, 2-р байранд Б.Ганбилэг 2-р цэцэрлэг, 3-р байранд Ш.Төгөлдөр 7-р цэцэрлэг тус тус шалгарлаа. 5 насны ангилалд 1-р байр Г.Гантөгс 2-р цэцэрлэг, 2-р байр А.Эвсанаа 2-р цэцэрлэг, 3-р байр Б.Ариундэлгэр 7-р цэцэрлэг, Уран дэвээ шаваатай бөхөөр Ч.Амин-эрдэнэ 4-р цэцэрлэг Уран мэх, уран барилдаанч бөхөөр Ш.Төгөлдөр-эрдэнэ 4-р цэцэрлэгийн бөх шалгарлаа.

Ерөнхий боловсролын сургуулиудын дунд "Ногоон гэрэл цагаан шугам 2013" тэмцээнийг зохион байгуулж нийт 8 ерөнхий боловсролын сургуулийн 8 багийн 160 хүүхэд оролцож, 1-р байр Сүхбаатар сумын 1-р сургууль, 2-р байр Сүхбаатар сумын 4-р сургууль, 3-р байр Сүхбаатар сумын 6-р сургуулийн багууд эхний 3 байранд шалгарлаа.

Сэлэнгэ аймгаас төрсөн Улсын арслан Боохой Данзангын хөшөөний нээлт, Ургацын баярт зориулсан үндэсний бөхийн барилдааныг 2013 оны 11 дүгээр сарын 12 нд Цагааннуур суманд зохион байгууллаа. Барилдаанд улс аймгийн цолтой 64 бөх барилдсанаас Монгол Улсын аварга Г.Эрхэмбаяр түрүү бөхөөр шалгарлаа.

## **3.Нийгмийн даатгалын талаар:**

Нийгмийн даатгалын сангуудад 18045.6 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 19011.5 сая төгрөг хурааж, төлөвлөгөөний биелэлт 105.3 хувьтай байна. Аймгийн хэмжээнд 19 нэгжээс 16 сум 1 тосгон нийгмийн

даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 2.2-35.8 хувиар давуулан биелүүлж, 1 сум 30 хувиар төлөвлөгөөг тасаллаа.

Тэтгэврийн даатгалын сангаас 14714 тэтгэвэр авагчдад 27569.7 сая төгрөгийн тэтгэвэр олгон, тэтгэмжийн даатгалын сангаас 4922 даатгуулагчдын хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн амаржсан, оршуулганд 1342.1 сая төгрөгийг зарцууллаа.

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 323 тэтгэвэр авагчдын 930.6 сая төгрөгийн тэтгэвэр, ажилгүйдлийн даатгалын сангаас 452 хүнд 343.4 сая төгрөгийн тэтгэмжийг олголоо.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 44167 хүний үй эеэүүй еэ çàðààèä, үй еей ñàí ääð çéè÷èççèñýí 10462 äààòõòõèää-äüí çàðààèä í èèð 1621.6 сая төгрөг шилжүүлээ.

Аймгийн í èéä èéí äààòäèüí öýèòñèéí äýðäýäýð Ýì í ýéýä õ° ä° èì ° ðèéí ì ääèèäõ èí èññ í ü 11 ñàðä 3 õààà õóðàèääæí èèò 191 õçí èé хөдөлмөрийн чадвар алдалтын õóäü, õóäèäàää öýéýèöýæ 195 õçí èé õóäü, õóäèäàää ñóí ääí 4 õçí èé хөдөлмөрийн чадвар алдалтúí õóäü õóäèäàää õóðàèæ 28 õçí èé õóäü, õóäèäàää ø èí ýýð õí äü í лóо.

#### **4. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:**

Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 1292 иргэнд 226835.8 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 738 иргэнд 111325.6 мянган төгрөг, жирэмсэн, хөхүүл нярай 2610 эхэд 924058.4 мянган төгрөг, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 52549.8 мянган төгрөгийг тус тус олголоо.

Алдарт эхийн 1, 2 дугаар зэргийн одонтой 8539 эхэд 1168540.0 мянган төгрөг хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээнд 201326.4 мянган төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 58 иргэнд 78660.0 мянган төгрөгийг тус тус олгоод байна.

#### **5. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:**

2013 оны 10 дугаар сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 746 хүн байсан бол 133 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 141 ажлын байранд 126 хүнийг ажилд зуучлан ажилгүйчүүдийн тоо тайлант сард 753 боллоо.

2013 оны 11 дүгээр сарын 5, 6-ны өдрүүдэд аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс нийт сумдын хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэнүүдэд “Хөдөлмөр эрхлэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ түүний үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдэвт нэгдсэн сургалт, зөвлөлгөөнийг зохион байгууллаа.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс нь ажил олгогчдоос 2014 онд “Мэргэжилтэй ажилтан бэлтгэх” сургалтын урьдчилсан захиалга авах ажлыг зохион байгуулж байна.

Ерөө, Баянгол, Сайхан, Орхонтуул, Хүдэр, Жавхлант, Түшиг сумдын 14 иргэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлд хамрагдан 39.0 сая төгрөгийн зээлийг олголоо.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс Мандал сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Мэргэжил бүхэн сайхан” сэдэвт сургалтыг Мандал сумын ерөнхий боловсролын сургуулийн 11-р ангийн 236 сурагчдад зохион байгууллаа.

#### **6. Хүүхэд залуучуудын талаар:**

“Нэр төрөө эрхэмлэх” даян дэлхийн өдөрт зориулж аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион бичлэгийн уралдаан зарлан дүгнэж уралдаанд шалгарсан шилдэг 50 бүтээлийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэхээр шийдвэрлэлээ.

“Хөгжилд хүүхдийн оролцоо Ү” аймгийн хүүхдийн чуулганыг зохион байгуулж 17 сум 6 тосгоны 100 хүүхэд хамрагдлаа.

Монгол Улсын Сангийн сайдын 2013 оны 157-р тушаалын дагуу олгогдсон 9.9 сая төгрөгийн 10 хувийг ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд, 90 хувийг байгууллагын тоног төхөөрөмжийн шинэчлэл хийлээ.

### **Тав.Хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны дотоод хяналт, үнэлгээний газрын ажлын хэсэг 2013 оны 11 дүгээр сарын 9-11-ний өдрүүдэд Шаамар, Мандал, Баянгол сумдад ажиллан “Ногоон хувьсгал” “Чацаргана” хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг шалгаж, энэ оны тариалалт, ургац хураалтын дүнтэй танилцлаа.

2014 î í ä Ñ¿ðáààòàð ñòì ùí òààðòí òýðýãýýò í °° öèéí ì àòû ã áýèòãýõ, ì àõí ù хангамжийг тогтворжуулах, үнийн хэт өсөлтийг хязгаарлах зорилгоор “Халиун уул” ӨОЁ-ий нийлүүлсэн үй ààí ù 5.1 òí ì àòû ã 1 êã 4780 ò° ãð° ã áóð ó í èèò 24.5 ñàý ò° ãð° ãèén òàðãà ò¿÷, öòñèàèò, °í Ñ, ø èí ýèýã áàéààè, çýðýã ñòàì ààðòòí ø ààðàèàãà òàì ãàñàí, 1, 2- ð çýðãèéí ì àè ýí í ýèýã àðèóí öýàðèéí ì àãàèèáí ø èí æèèãý, ãðàè ç¿ñèèéí áè÷èèãýé áýèòãýãñýí ì àòû ã Ñýýíý ãý ¿èè÷èèãý Í Í ° ÀÀÕ Æ-ùí ò° ðã èòòýé ì àõí ù çí î ðèí ä ò¿èýýí àà÷ ¿í ýèýèò ä¿ã ýèò ° ã: àæèèèàëà.

Япон улсын засгийн газрын хөнгөлөлтэй зээлийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжиж буй “Хөдөө аж ахуйн” техникийн шинэчлэл хийх төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг 67 аж ахуйн нэгж, 9 иргэний техникийн захиалгыг авч материалыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яаманд хүргүүлжээ.

Аймгийн өвсний нөөц бүрдүүлэх зорилгоор Орхон сумаас 2000 боодол өвс, Сүхбаатар суманд 3000 боодол өвс бүгд 125 тн тус бүр 50-80 тн хивэг тэжээлийн будаа авахаар гэрээ хийн нөөцийг бүрдүүлээд байна.

Мал эмнэлэг үржлийн алба үүсэн байгуулагдсаны 90 жилийн ойг 2013 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж, ойн арга хэмжээнд аймгийн Засаг С.Бүрэнбат, ҮХААЯ-ны Мал эмнэлэг үржлийн газрын дарга М.Галбадрах, сумдын мэргэжилтэн, ахмад мэргэжилтнүүд зэрэг 160 гаруй төлөөлөгчдийг оролцуулан тэмдэглэн өнгөрүүлжээ.

2013-2014 оны өвөл, хавар тус аймагт 7399 малчин болон мал бүхий өрхөд 1,2 сая мал өвөлжихөөр зохион байгуулагдаж байна.

### **Зургаа. Газрын харилцаа, Байгаль орчны бодлогын хүрээнд:**

#### **1.Газрын харилцааны талаар:**

Тус аймгийн Сүхбаатар суманд 2013 оны 11 сарын 2, 3-ны өдөр GNSS-ийн станцыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Гео-Инструмент ХХК хамтран суурилуулах ажлыг гүйцэтгэлээ.

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас “Газрын даамлын үйл ажиллагаа, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг чанаржуулах нь” сэдэвт сургалт семинарыг аймгийн нийт сумдын газрын даамлуудыг хамруулан зохион байгууллаа.

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн дагуу хамтран өмчлөх эрхээ хэвээр үлдээх 4 иргэн, 13 иргэний газар өмчлөх эрхээ нээлгэх хүсэлтийг хүлээн аван шийдвэрлэлээ.

Газар өмчлөх эрхээ тухайн орон нутагт хэрэгжүүлсэн эсэх лавлагааг Сүхбаатар сумын 15 иргэнд Алтанбулаг, Шаамар болон бусад аймаг, нийслэлд газар өмчлөх хүсэлтийн дагуу гаргаж өглөө.



Алтанбулаг, Баянгол, Мандал, Орхон, Сайхан, Шаамар сумдын нийт 26 иргэний өмчилсөн газрыг кадастрын мэдээллийн санд бүртгэж баталгаажуулан Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүллээ.

Эзэмшиж ашиглаж буй газраа эдийн засгийн эргэлтэнд оруулж арилжааны банкинд газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалсан тухай улсын бүртгэлд 1 аж ахуйн нэгж 22 иргэний нийт 22 нэгж талбарыг бүртгэж аймгийн төрийн санд тэмдэгтийн хураамжийн 220000 төгрөгийг төвлөрүүлсэн байна.

## **2.Байгаль орчны талаар:**

Аймгийн Байгаль орчны газраас тус аймгийн Баянгол сумын нутагт орших Бороогийн алтны үндсэн ордод ашиглалт явуулдаг “Бороо гоулд” ХХК-ий газрын доорх усны дотоод хяналтын цэгт байрлах MW8 ажиглалтын цооногийн кондуктор янданг тайрах ажилд хяналт тавьж, акт тогтоолоо.

Аймгийн Байгаль орчны газраас Хушаат сумын мод бэлтгэлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалтын ажил хийлээ.

## **3.Тээвэр авто замын талаар:**

Аймгийн Тээвэр авто замын газар, Авто тээврийн үндэсний төвийн Сэлэнгэ аймаг дахь салбартай хамтран нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тээврийн хэрэгслийн давтан үзлэгийг аймгийн хэмжээнд бүсчилсэн байдлаар Мандал, Баянгол, Сайхан, Сүхбаатар сумдад төвлөрүүлэн зохион байгуулан ажиллаж байна.

Хот хооронд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлдэг "Зэлтэрийн зам" ХХК, "Мон-Тбб" ХХК-иудын тээврийн хэрэгсэлд өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулж байгаа байдал, Улсын чанартай авто замаар хүнд даацын тээврийн хэрэгслээр тээвэр эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тээвэрлэлтийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгсэл, ачааны байдалд явуулын пүүг ашиглан “Авто замын тухай”, “Автотээврийн тухай”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулиуд түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартуудын хэрэгжилтэнд аймгийн Тээвэр авто замын газраас хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

## **Долоо.Сүм орон нутгийн талаар:**

### **1.Баруунбүрэн сум:**

Тус сумын удирдлагууд айл өрхүүдээрээ тойрон иргэдтэйгээ уулзаж цаг үеийн ажлын мэдээлэл хийн, сумын 90-н жилийн ойн баяраар ямар бүтээлч ажил хийх талаар иргэдтэй санал бодлоо солилцон, өвөлжилтийн байдалтай газар дээр нь танилцаж, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг авч шийдвэрлэх арга замын талаар санал бодлоо солилцлоо.

2013 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр тус сумын Засаг даргын Тамгын газраас “Бүтээлч ажил 90” сэдвийн хүрээнд сумын удирдлагууд, ахмадын төлөөлөл, залуучуудын төлөөлөл, төсвийн байгууллагуудын удирдлагууд, иргэдийн төлөөлөл, аж ахуйн нэгжүүдийн захирал эрхлэгч нарын дунд чөлөөт хэлэлцүүлэг зохион байгууллаа.

2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр сумын Засаг даргын Тамгын газраас тус сумын төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгж иргэдийг хамруулсан урлаг спортын үйл ажиллагааг зохион байгууллаа.

Тайлант сард аймгийн Татварын хэлтэс тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран 2013 оны 11 дүгээр сарын 13-20-ны өдрүүдэд Баруунбүрэн суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийх ажлыг зохион байгууллаа.

### **2.Баянгол сум:**

### **3.Ерөө сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас сумын нутаг дэвсгэр болох Хүзүүвчийн өвөр, Дэнжийн гацал, Гүнтолгой, Хонгорын нуруу, Буйлааст зэрэг газруудад өвөлжиж буй 40 гаруй малчин өрхөөр орж өвөлжилтийн байдалтай танилцаж бэлчээрийн татварын тухай мэдэгдэл хүргүүлж, санал хүсэлтийг нь хүлээн авлаа. Мөн бэлчээр, хадлангийн газрын төлбөрт 1185.0 мянган төгрөгийн татвар хурааж, 2500.0 мянган төгрөгийн мэдэгдэх хуудас хүргүүлж ажиллалаа.

2013 оны 11 дүгээр сарын 1, 2-ны өдрүүдэд тус сумын Засаг даргын Тамгын газар “Хөгжил дэвшлийн хөтөч” менежментийн сургалтын төв хамтран “Байгууллагын хөгжил ба амжилт” сэдэвт 2 өдрийн сургалтанд сумын Засаг даргын Тамгын газрын 14 албан хаагч хамрагдлаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Экологийн боловсролын төвтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн 600 сурагч, Хүдэр, Жавхлант сум, Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн багш нар, сумын олон нийт удирдах ажилтан 73 нийт 673 хүнийг хамруулан экологийн боловсрол олгох, эко сургууль хамт олныг бүрдүүлэх зорилгоор 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа.

Чихрийн шижин өвчинтэй тэмцэх дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан төрийн албан хаагчдын дунд чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулж биеийн жин өндөрийг тодорхойлж, цусны даралт хэмжиж, Чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх, Хөдөлгөөн эрүүл мэнд, Зохистой хооллолт сэдвүүдээр мэдээлэл хийлээ.

### **4.Мандал сум:**

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хамтран 2013 оны 11-р сарын 15-ны өдөр “Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх нь” сэдэвт 1 өдрийн сургалтыг тус суманд зохион байгуулж 4 аймаг 7 сумын нийт 90 гаруй албан хаагчид хамрагдлаа.

Мандал сумын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын сургуультай хамтран сурагчдыг эх орноороо бахархах, үзэл төлөвшүүлэх зорилгоор ерөнхий боловсролын болон Мэрэгжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 9-11 ангийн сурагчдын дунд “Би Монгол бахархал” илтгэлийн уралдааныг зохион байгуулж нийт 20 хүүхдийн бүтээлээс эхний 3 байрыг шалгаруулан өргөмжлөл, алтан медаль дурсгалын зүйл гардууллаа.

Монгол Улс Тунхагласаны тэмдэглэлт өдрийг тохиолдуулан 16 нас хүрч иргэний үнэмлэхээ шинээр гардан авч буй өсвөр үеийн хүүхэд залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх, Монгол Улсын иргэний андгай өргөх ёслолын ажиллагааг зохион байгууллаа.

### **5.Орхон сум:**

Тайлант хугацаанд тус сумын Засаг даргын Тамгын газраас төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах, бодлого боловсруулах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор иргэдэд орон нутгийн цаг үеийн мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулан, сумын 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах санал, төр төсвийн байгууллагын дарга эрхлэгч, төрийн захиргааны албан хаагчдын ажил үйлчилгээний талаарх санал, сум хөгжүүлэх сангийн 2014 оны тэргүүлэх чиглэл, зээлийн хэмжээ, хүү, хугацааг тодорхойлох талаар иргэдээс санал асуулгуудыг авч давхардсан тоогоор нийт 884 өрх иргэнийг хамрууллаа.

Сумын Засаг даргын 2013 оны А/23 тоот захирамжаар “Тамхины хяналтын тухай” хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих ажлын хэсэг байгуулагдан тайлант сард

сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг нь албан байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалт хийлээ.

2013 оны бог малын зохиомол хээлтүүлгийн ажлыг сумын Засаг даргын 2013 оны А/186 тоот захирамжаар нийт 16 хоногийн хугацаанд Бэлэндалай багийн нутаг дэвсгэр болох Агьтийн хошуунд зохион байгуулж 3 аж ахуйн нэгж, 1 малчин өрхийн нийт 867 толгой Орхон үүлдрийн хонинд зохиомол хээлтүүлгийг явуулж ажлын гүйцэтгэл 102 хувьтай байна.

#### **6.Орхонтуул сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас төрийн байгууллагын ажил үйлчилгээний талаар иргэдэд мэдээлэл хийх зорилгоор 14 хоног тутам сумынхаа айл өрхөөр орж ажиллаж байгаа бөгөөд тайлант сард 150 гаруй өрхийн иргэдтэй уулзаж тэдний санал хүсэлтийг хүлээн авч мэдээлэл хийлээ.

Орхонтуул сумын Засаг даргын Тамгын газраас эрхлэн гаргадаг “Орхонтуулын мэдээ” сонинг хэвлүүлж иргэдэд хүргэх ажлыг зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас сумын Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж сумын төв, Рашаант тосгоныг утасгүй интернетийн сүлжээнд холболоо.

Тус сумын иргэдээс архи, согтууруулах ундаа худалдаалж байгаа талаар ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу сумын Засаг даргын Тамгын газар, цагдаагийн хэсэгтэй хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж зөвшөөрөлгүй архи, согтууруулах ундаа худалдаалж байсан 1 цэгийн архи, согтууруулах ундааг хураан авч хуулийн дагуу арга хэмжээ авлаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн төв хамтран 2013 оны 11 дүгээр сарын 14-ий өдөр “Чихрийн шижингээс урьдчилан сэргийлэх” өгөгдөл ажиллагааг 40 гаруй иргэд оролцож амжилттай өгжээ.

#### **7.Сайхан:**

Аймгийн Онцгой байдлын газар, тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран сумын Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг “Газар хөдлөлт, малын халдварт өвчний хор уршгийг арилгах үеийн нутгийн захиргааны байгууллага, томилгоот бие бүрэлдэхүүний харилцан ажиллагаа” сэдвээр зохион байгууллаа. Сургуулилтанд бие бүрэлдэхүүнд нийт 8 албаны 12 бүлгийн 241 хүн, 17 техник хэрэгсэл ажиллалаа.

Сайхан сумын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын сургууль хамтран сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох, анги кабинетийн эрүүл ахуйг сайжруулах зорилгоор “Эрүүл монгол хүүхэд” аяныг зохион байгуулж, бага ангийн сурагчид болон цэцэрлэгийн хүүхдүүдийн үдийн хоолны эрүүл ахуйд хяналт шалгалт хийлээ.

Ажилгүй хөдөлмөр эрхлэхийг хүссэн 10 иргэнийг ажил идэвхтэй хайгчдын бүртгэлд бүртгэн, 3 ажил олгогчоос ирүүлсэн ажлын байрны захиалгыг авч, 16 хүнийг ажлын байранд зуучиллаа.

Сайхан сумын Засаг даргын 2 удаагийн захирамжаар 2 иргэн аж ахуйн нэгжид газар эзэмшүүллээ. Мөн 19 иргэнд газар өмчлүүлэх захирамж, өөрчлөлт оруулах тухай 3 удаагийн захирамж, 5 иргэн, аж ахуй нэгжид 5 удаагийн захирагчид 6 өргөдөл, гомдлын дагуу сумын Засаг даргын Тамгын газар, цагдаагийн хэсэгтэй хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж зөвшөөрөлгүй архи, согтууруулах ундааг хураан авч хуулийн дагуу арга хэмжээ авлаа.

#### **8.Сант сум:**

Төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагааг ард иргэдэд ил тод нээлттэй байлгах, сурталчилан танилцуулах, төр, аж ахуйн нэгж байгууллагууд, иргэдийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааг сайжруулах зорилго бүхий тус сумын Засаг даргын 2013 оны А/96 тоот 14 хоногийн аян зохион байгуулах тухай захирамжийн

хэрэгжилтийг ханган газар тариалан, байгаль хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгал, газрын харилцааны чиглэлээр иргэдэд сургалт зохион байгуулж, уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг хийлээ.

Ной үй өй аяуи ä 98 өрхийн í èèð 3440 çððèã ýýì ýæýì áçððäýèæçèæ çðæèèí áçððäýè äýð-èèäýý í èã ð àæù äðèèæäçèöýðäýлээ.

Газар зохион байгуулалтын 2014 оны төлөвлөгөөний төслийг боловсруулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, газрын төлбөрийн 1100.0 мянган төгрөгийг аймгийн төрийн санд төвлөрүүлээ.

Тайлант сард “Удам угсаагаа мэдэж угийн бичиг хөтөлцгөө” уралдааны дагуу сант ñòì ùí öýì æýýí ä 1 ñàðùí àýì çì òèí í áàèãòóèè àèè °ðð, àèáàì áàèãòóèèäãòóààä “Ургийн бичгийн утга учир” нэртэй сургалтыг зохион байгуулж í èèð 80 гаруй èðäýд òàì ðàããалаа.

### **9.Зүүнбүрэн сум:**

Дархан-уул аймгийн худалдаа аж үйлдвэрийн танхимаас тус суманд зохион байгуулсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг тус суманд ажиллаж 98 иргэдээс санал асуулга авч 68 хувийн гүйцэтгэлтэйгээр дүгнэгдлээ.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд тус сумын иргэдийн түлшний модны хэрэглээнд зориулж Зүүнбүрэн сумын Засаг дарга, Цагааннуур сумын Засаг даргатай гэрээ байгуулж, хөнгөлөлттэй үнээр иргэдэд түлшний мод олгохоор гэрээнд тусгалаа.

Сумын Засаг даргын 2013 оны А/152 тоот захирамжаар Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, сумын төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийх ажлыг зохион байгууллаа.

Тус сумын Бэлчирийн 2 дугаар багт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль болохтой холбогдуулан тус багийн иргэдийн шилжин суурших хөдөлгөөнийг санал хураах өдрийг дуусах хүртэл түр хугацаагаар зогсоогоод байна.

“Алтан намар -2013” арга хэмжээний үеэр “Усалгаагүй нэгж га талбайгаас хамгийн их ургац хураан авсан аж ахуйн нэгж”, 2013 оны “Газар тариалангийн шилдэг мехникжуулагч”, “Нэгж га талбайгаас хамгийн их төмс, хүнсний ногоо хурààí àãñàí иргэн”, “Хамгийн их жимс, æèì ñäýì э хураан авсан иргэн”, “Хамгийн их борлуулалт òèèñýì èðäýì ” зэрэг номинацуудаар шалгаруулж, шагнаж урамшууллаа.

### **10.Сүхбаатар сум:**

2013 оны 11 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Санжжав тэргүүтэй ажлын хэсэг тус суманд ажиллалаа. Ажлын хэсэг Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа, багийн байр болон “Сум хөгжүүлэх сангийн зээл” авч шинээр ажлын байр бий болгосон аж ахуйн нэгж, иргэдтэй уулзан тэдний санал хүсэлтийг хүлээн авч ажил байдалтай нь танилцлаа.

Сэлэнгэ амьдрах сайхан Төрийн бус байгууллагын Эрүүл идвэхитэй амьдрах клубээс зохион байгуулж буй “Амьдрах ухааны урлаг” сэдэвт өдөрлөгөөр Улаанбаатар хотын Амьдрал судлалын академийн ерөнхийлөгч, шилдэг лектор Ж.Цогтсугар нь архидан согтуурснаас шалтгаалан гарч буй гэмт хэргийг таслан зогсоох зорилгоор Сүхбаатар сумын засаг даргын Тамгын газартай хамтран төр төсвийн байгууллагуудын ажилчид албан хаагчдыг хамруулсан сургалтыг зохион байгууллаа.

2013 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр “Жижиг дунд үйлдвэрлэлийг 2014-2016 онд хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төсөлд тусгах иргэдийн санал хэлэлцүүлэг тус сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд зохион байгуулагдлаа.

Сүхбаатар сумын “Ногоочдын зөвлөгөөн”-ийг тус сумын Засаг дарыг Тамгын газраас 2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгууллаа.

Канадын “Амийн мод сэргэлт” олон улсын байгууллагаас тус сумын иргэдэд “Жимс жимсгэний мод тариалах болон хамгаалалтын зурвас татаж тариалах арга” сэдэвт сонирхолтой сургалтыг зохион байгууллаа.

#### **11.Хүдэр сум:**

Тус сумын Засаг даргын 2013 оны “Мэдээ мэдээлийн ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” захирамжийн хэрэгжилтийг хангаж орон нутгийн тусгай нэвтрүүлэг явуулах зорилгоор хэвлэл, мэдээллийн ажилтны орон тоог бий болгож, 4300.0 мянган төгрөгийн теле студийн тоног төхөөрөмж авч, 14 хоног тутам орон нутгийн ажил амьдралын асуудлаар нэвтрүүлэг хийж байхаар шийдвэрлэлээ.

Тайлант сард “Хүдэрийн мэдээ” сонинг хэвлэн сумын ард иргэдэд хүргүүллээ.

Аймгийн нэгдсэн эмнэлэг тус сумын Засаг дарга хамтран Хүдэр сумын иргэдэд “Архигүй гэр бүл” сэдэвт сургалт зохион байгуулж нийт 61 иргэн хамрагдлаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас нийт газар тариалангийн талбайд тооллого явуулж нийт 224 талбай тоологдож, 18 талбай зөрчилтэй гарсныг солбицлын цэгийг тогтоолоо.

Тайлант сард сумын Засаг даргын Тамгын газраас ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хууль бусаар мод бэлтгэх явлыг таслан зогсоох зорилгоор 5 удаа эргүүл шалгалт хийн, зөрчил гаргасан иргэдийг түр саатуулан 3 иргэнд захиргааны арга хэмжээ авч 3 иргэний хэргийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, иргэдэд 113м<sup>3</sup> түлээний зөвшөөрөл олгож, 282.5 мянган төгрөгийг төсөвт орууллаа.

Тус сумын Мал эмнэлэг үржлийн алба үүсэн байгуулагдсаны 90 жилийн ойн арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулж, үе үеийн мал аж ахуйн мэргэжилтнүүдийн уулзалт зөвлөлгөөнийг зохион байгууллаа.

#### **12.Цагааннуур сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас 2013 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр “Сахилгын шийтгэл ногдуулах, хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх”, “Ахмад настанд олгох хөнгөлөлт тусламж”-ийн тухай сургалтыг зохион байгуулж нийт 22 хүн хамрагдлаа.

Аймгийн Онцгой байдлын газар, сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах” сургалтыг 2013 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төр төсвийн байгууллага, худалдаа үйлдвэрлэл эрхлэгчид болон аж ахуйн нэгж, иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, гамшгийн эрсдэлийг хэрхэн бууруулах талаар сургалтыг сумын соёлын төвд зохион байгуулж нийт 65 өдөж бэлтгэж өгөв.

Монгол Улсын Сангийн яам, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг дахь худалдаа аж үйлдвэрийн танхимаас явуулсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн судалгааг тус сумын иргэдээс авч санал асуулгад нийт 98 иргэн хамрагдан, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн үнэлгээ 87.5 хувьтай дүгнэгдлээ.

Сумын 2013 оны 08-ны өдөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төр төсвийн байгууллага, худалдаа үйлдвэрлэл эрхлэгчид болон аж ахуйн нэгж, иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, гамшгийн эрсдэлийг хэрхэн бууруулах талаар сургалтыг сумын соёлын төвд зохион байгуулж нийт 65 өдөж бэлтгэж өгөв.

Сумын 2013 оны 08-ны өдөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төр төсвийн байгууллага, худалдаа үйлдвэрлэл эрхлэгчид болон аж ахуйн нэгж, иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, гамшгийн эрсдэлийг хэрхэн бууруулах талаар сургалтыг сумын соёлын төвд зохион байгуулж нийт 65 өдөж бэлтгэж өгөв.

Сумын 2013 оны 08-ны өдөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төр төсвийн байгууллага, худалдаа үйлдвэрлэл эрхлэгчид болон аж ахуйн нэгж, иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, гамшгийн эрсдэлийг хэрхэн бууруулах талаар сургалтыг сумын соёлын төвд зохион байгуулж нийт 65 өдөж бэлтгэж өгөв.

Сумын 2013 оны 08-ны өдөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төр төсвийн байгууллага, худалдаа үйлдвэрлэл эрхлэгчид болон аж ахуйн нэгж, иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, гамшгийн эрсдэлийг хэрхэн бууруулах талаар сургалтыг сумын соёлын төвд зохион байгуулж нийт 65 өдөж бэлтгэж өгөв.

Тус аймгийн Сэлэнгэ бүсийн Цагааннуур, Зүүнбүрэн, Түшиг сумдын дунд “Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл 2013” үзэсгэлэн худалдааг 2013 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Цагааннуур суманд зохион байгууллаа.

Үзэсгэлэн худалдаанд Цагааннуур, Түшиг сумын 2 аж ахуйн нэгж, 43 иргэн хамрагдсан бөгөөд үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлын хэсэг 9 номинаци шалгарууллаа.

### **13.Шаамар сум:**

Аймгийн Стандарчлал хэмжил зүйн хэлтэс тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Дэлхийн чанарын өдөр”-ийг тохиолдуулан Үндэсний чанарын 7 хоног арга хэмжээний хүрээнд “Сэлэнгэд үйлдвэрлэв” брэнд бүтээгдэхүүний өдөрлөгийг 2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгууллаа. Өдөрлөгөөр аймгийн брэнд бүтээгдэхүүн болох Утсан загас, Хмелийн талх, Шилмэл эсгий, арьс нэхий болон сумын брэнд бүтээгдэхүүн болох Шижир зөгийн бал, савласан ногоо, салат, хүнсний бүтээгдэхүүн, төрөл бүрийн салат гэх мэт бүтээгдэхүүнүүдээр үзэсгэлэн худалдаа зохион байгууллаа.

Тус сумын удирдлагууд багийн алслагдсан айл өрхүүдээр явж өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцаж, цаг үеийн талаар мэдээлэл хийн, тэдний санал хүсэлт, тулгамдаж буй асуудлыг хүлээн авч, шийдвэрлэх арга замын талаар санал, бодлоо солилцлоо.

Тус сумын Засаг дарга иргэдийн түлээ нүүрсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Түшиг сумын “Улаан овоо”-ны нүүрсний уурхайтай гэрээ байгуулж 1 тн нүүрсийг 50.200 төгрөгөөр орон нутагт нь авчирч борлуулахаар шийдвэрлэлээ.

Үндэсний өв соёлоо дэлгэрүүлэн сурталчлах “Дээлтэй монгол” хөдөлгөөний хүрээнд “Монголоороо гоёцгоо” сэдэвт уралдааныг Тус сумын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын сургуультай хамтран Ардын дуу болон харилцаа дуу, Задгай цагаан, Хүмүүн төрөлхтөн бүжгүүд, Ардын зан үйлийн холбогдолтой асуулт хариултын “Азаа үзэж оюун ухаанаа” сорьцгооё тэмцээнүүдийг зохион байгууллаа.

### **14.Түшиг сум:**

Тус сумын Засаг даргын 2013 оны А/145 тоот захирамжаар төрийн үйл чилгээний ил тод байдлыг хангах, иргэдэд цаг үеийн холбогдох мэдээ мэдээллийг хүргэх, тэдний санал хүсэлтийг хүлээж авах зорилгоор сумын Засаг даргын Тамгын газраас тайлант сард сумын айл өрхүүдэд орон нутгийн хэмжээнд 2013 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулан, төрийн албан хаагчдийн ёс зүй, үйлчилгээний талаар иргэдээс санал асуулга авч ажиллалаа.

Тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2013 оны 46 тоот тогтоолоор Жаргал мандах 1 дүгээр багт нөхөн сонгууль явуулах үйл ажиллагааг зохион байгууллаа.

2014 онд тариалах үрийн нөөцөнд 630 тн улаанбуудайн үр нөөцөлснөөс үрийн дээж авч аймгийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлээ.

Цагааннуур суманд зохион байгуулагдсан Сэлэнгэ бүсийн сумдын “Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл-2013” үзэсгэлэн худалдаанд тус сумын “Кимчи” брэнд 1 дүгээрбайр эзэлж, Оёдол эсгүүр 2-р байр эзэлсэн амжилтыг үзүүлээ.

“Буу-2013” аяны хүрээнд ажлын хэсгийн бүрэлдэхүүн хамтран буутай иргэн бүрээр явж зураг аван баримтжуулж татвар хураах, шинээр бүртгэх, хасалт хийлгэх зэрэг ажлуудыг зохион байгуулж, мэдээллийн санд баяжилт хийлээ.

### **15.Хушаат сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Хушаат сумын хөгжлийн гарц” сэдэвт илтгэл, нийтлэлийн уралдааныг 2013 оны 11 дүгээр сарын 20-оос 12 дугаар сарын 20 хүртэлх хугацаанд зохион байгуулж байна.



áàéãóóèèàãí 328 ажилтан албан хаагч нарыг хамруулан “Гамшгаас хамгаалах тухай”, “Галын аюулгүй байдлын тухай”, “Ой хээрийг түймрээс хамгаалах тухай” хуулиуд, амшгаас хамгаалах арга хэмжээний зохион байгуулалт, арга хэмжээний төлөвлөлт сэдвээр 10 цагийн сургалт зохион байгууллаа.

Тайлант хугацаанд аврах, гал унтраах ангиуд нийт 9 оáààæéí î áúâèòúí æè òçéì ðèéí áóóäèàãàð ãð÷ áàééäààí ù òàðòàèò ðèéí àæèèäáí 7 æè òçéì ðèéí 1 òàñæéí òç÷ýýð, 51 тонн ус, 340.7 литр шатахуун зарцуулан оí òðààæ æè òçéì ðèéí àð òèààñ èðãýà, áàéãóóèèàã, àæ àóóéí íýæèéí 38 ñàý òð ãð æéí ò ÷ òð òí æéá ààðáí òàí æàèëàà.

Ààì ø èã î ñî è, æè òçéì ýð óí òðààò áýèòãýè áýéýí áàéäèùã òáí æò, àãðàã-, æè ñ° í° ã-àèéí òóàèéí áýèòãýè, òçí íýã áçðèéí òóàèéí çýãñýæýí æ òýããýðèéí àø èæàèò, òããæèàèòúí áàéäàèä ççéýã ø àèæèèòúã 4 óààà ðèéæ èèýðñýí ç° ð÷èè áóòàãèèùã àðèèãóóèàò òóãòààòàé ççðýã áààèæãààð °ã- áéãéýèðèéá òí îí æ òãí èè áàææ çýãñýæýí æà ðèèãýò çãñààð çéè÷èèãýí èé áàòèàãñáí òóààððèéí áàãò °ã° èæèèðèéí áýèòãýè àæèùã òáí æò òçðýýí à æè óí òðààò çí ðèóèàèòúí àãòí àø èí óóàà òãí èèèéí 1 äçãýð çéè÷èèãýý 10 óààà, òãí èèèéí 2 äóãàð çéè÷èèãýý 4 óààà ðèéæ 31 òð ðèèéí 1149.5 ì ýí æáí òð ãð æéí ñýéáýã òýðýãýè çàðòóóèèáí ààñ æáí à ì àø èí òãí èè áàææ òýðýãýè 81 òð ðèèéí 475.0 ì ýí æáí òð ãð æéí ñýéáýã òýðýãýèèèã° ðñàèéí áí òí à í° ò áí èí èòí ì ì ð ðèéæãýíçэтгэлээ.

#### **Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:**

Сүхбаатар, Сайхан, Шаамар, Мандал, Ерөө, Баянгол, Баруунбүрэн сум, Түнхэл тосгоны 36 аж ахуй нэгжид тохирлын үнэлгээ хийснээс 24 аж ахуйн нэгжид тохирлын гэрчилгээ олгож, Мандал сумын Түнхэл тосгоны 23 худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт тохирлын үнэлгээ, баталгаажуулалт, Худалдааны газрын үйлчилгээ, стандартаар мэдээлэл хийлээ.

Сүхбаатар, Сайхан сумын 6 аж ахуйн нэгж, иргэний 4 нэрийн 8 хүнсний бүтээгдэхүүнийг баталгаажуулалтанд хамруулж, лабораторийн сорилт шинжилгээг үндэслэн дүгнэлт гаргалаа. Экспортын бүтээгдэхүүний баталгаажуулалтыг “Алтан тариа” ХХК-ий экспортлож байгаа Буудайн хивэгний 5 удаагийн тээвэрлэлт, “Хөтөл Цемент” ХК-ий Портланд цементний 7 удаагийн тээвэрлэлтэнд баталгаа гаргаж, тохирлын гэрчилгээ олголоо.

“Стандарт, хэмжил зүй-Таны амьдралд” аяны хүрээнд Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 7 сургуулийн 29 бүлгийн 452 сурагчдад мэдээлэл өгч, “Стандарттай монгол” сэдэвт зохион бичлэгийн уралдаан зарлаж, эхний байрт шалгарсан сурагчид зохион бичлэгээ Дэлхийн чанарын өдрийн онол практикийн бага хурлын оролцогчдод уншиж танилцуулан, бүтээгдэхүүний чанарын талаарх өөрсдийн сэтгэгдлийг илэрхийллээ.

Айл өрх, аж ахуй нэгж, албан байгууллагын төлбөр тооцоонд ашиглагдаж байгаа 1 фазын 33 цахилгаан тоолуурт ээлжит баталгаажуулалт хийлээ.

7 сумын 19 шатахуун түгээх станцын шатахуун түгээгүүрийн 67 шингэн хэмжигчийг ээлжит баталгаажуулалтанд хамрууллаа.

#### **Мэргэжлийн хяналтын газар:**

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан нэгдсэн удирдамжийн хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг хяналт шалгалтанд хамруулж байна. Тайлант сард Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг хяналт шалгалтанд хамрууллаа.



Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас эхний 11 сарын байдлаар нийт 1944 объектыг хяналт шалгалтанд хамруулж, 3162 зөрчил илрүүлэн, 13346.6 мянган төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулж шийдвэрлээд байна.

Тайлант сард нийт 14 удирдамж боловсруулан, 14 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, 18 зөрчил илрүүлэн, 1920.0 мянган төгрөгийн торгууль, 967.6 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдууллаа.

Мэргэжлийн хяналтын газрын дэргэдэх итгэмжлэгдсэн лаборатори нь 11-р сард нийт 12 аж ахуйн нэгжийн 6 нэр төрлийн 41 дээжинд 68 үзүүлэлтээр хими, нян судлал, ургамал хорио цээрийн шинжилгээг хийхэд 1 нэрийн 1 дээж 3 үзүүлэлтээр эерэг гарлаа.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР